



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 291

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дархан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 10 нэрийн, нийт 100,869,572.70 (нэг зуун сая найман зуун жаран есөн мянга таван зуун далан хоёр төгрөг далан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.“Дархан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001430

15-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
229/дугаар тогтоолын хавсралт

"ДАРХАН АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ-ДАНСНААС ХАСАХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуриутлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Старекс, ДАР 04-35	2001-01-01	ш	1	22,377,872.70	22,377,872.70	0.00
2	Эксковатор, ДА 90-33	2009-09-03	ш	1	60,753,700.00	60,753,700.00	0.00
3	Зөөврийн компьютер /acer I5-480/	2018-03-21	ш	1	1,946,000.00	1,946,000.00	0.00
4	Зөөврийн компьютер /acer I5-7200/	2018-03-21	ш	1	2,014,000.00	2,014,000.00	0.00
5	Сандал /Оффис/	2018-06-18	ш	1	108,000.00	108,000.00	0.00
6	Принтер Samsung M2070	2018-06-18	ш	1	390,000.00	390,000.00	0.00
7	Компактор JPC-80	2014-01-01	ш	1	2,000,000.00	2,000,000.00	0.00
8	Газар ухагч өрөм	2018-09-19	ш	1	350,000.00	350,000.00	0.00
9	Гар индүү /2 бүлт/	2018-01-14	ш	1	8,000,000.00	8,000,000.00	0.00
10	Уурын зуух	2017-12-21	ш	1	2,930,000.00	2,930,000.00	0.00
	Нийт дүн			10	100,869,572.70	100,869,572.70 (нэг зуун сая найман зуун жаран есөн мянга таван зуун далан хоёр төгрөг далан мөнгө)	